

МУИС-ИЙН ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭЛЭНД ОЮУТАН ДАДЛАГАЖУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Оюутан Монгол Улсын Их Сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн (цаашид “Хүрээлэн” гэх) -д дадлага хийх харилцааг энэ журмаар зохицуулна.

Хоёр. Дадлагажих оюутан сонгон шалгаруулах журам

2.1. Хүрээлэнд оюутан дадлагажуулах ажлыг хүрээлэн хариуцан зохион байгуулна.

2.2. Хүрээлэнд дадлага хийх оюутанд дараах шаардлага тавигдана.

- Магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн их, дээд сургуулийн өдрийн ангийн оюутан байх (үйлдвэрлэлийн дадлагажигч оюутаны хувьд төгсөх курсийн оюутан байх, практикийн болон урамшуулалгүйгээр дадлагажигч оюутны хувьд 2-оос дээш курсийн оюутан байх)
- Сурлагын голч дүн 3.0 ба түүнээс дээш байх
- Үндсэн хуулийн эрх зүйн чиглэлээр судалгаа хийх хүсэл эрмэлзэлтэй байх
- Ямар нэгэн гадаад хэлний мэдлэгтэй байх
- “Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнд оюутан дадлагажуулах журам”-тай танилцаж, зөвшөөрсөн байх

2.3. Хүрээлэнд дадлагажих оюутанг сонгон шалгаруулах ажил нь 2 үе шаттай байна.

2.4. Хүрээлэнд дадлага хийх хүсэлтэй оюутан дараах материалыг жил бүр 04 сарын 01-ны өдрөөс 05 сарын 31-ны өдрийг хүртэл хүрээлэнгийн цахим хаяг болох cli@num.edu.mn -рүү илгээнэ.

- CV (CV нь чөлөөт хэлбэртэй байна)
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Сурч буй сургуулийн гэрчилгээ
- Сурлагын дүнгийн хуулбар
- Гадаад хэлний төвшин тогтоох шалгалтын гэрчилгээ (зөвхөн байгаа хүмүүст хамаарна)
- Яагаад тус хүрээлэнд дадлага хийх хүсэлтэй байгаа тухай эссэ (эссэ нь чөлөөт хэлбэртэй байх бөгөөд А4-ийн 2 нүүрнээс хэтрэхгүй байх)
- Өөрийн гүйцэтгэж байсан судалгааны бүтээлүүдийн хуулбар

2.5. Хүрээлэн нь материалын шалгалруулалтанд тэнцсэн хүмүүст 06 сарын 15 -ны дотор утсаар мэдэгдэнэ.

2.6. Эхний шалгаруулалтанд тэнцсэн оюутнуудаас ярилцлага авах бөгөөд ярилцлаганд тэнцсэн оюутанд утсаар мэдэгдэнэ. Ярилцлага зохион байгуулагдах өдрийг хүрээлэнгийн цахим хуудсаар дамжуулан мэдэгдэнэ.

Гурав. Хүрээлэнд оюутан дадлагажуулах харилцаанд оролцогчдын эрх, үүрэг

3.1. Хүрээлэн нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. дадлагажигч оюутны ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

- 3.1.2. хүрээлэнгээс явуулж буй үйл ажиллагаа болон судалгааны талаарх мэдээллээр оюутныг хангах;
 - 3.1.3. үйлдвэрлэлийн дадлагажигч оюутны хувьд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр, практикийн дадлагажигч оюутны хувьд ажилласан цагийн хөлсөөр урамшуулал олгох;
 - 3.1.4. дадлагажих хүсэлт гаргасан оюутнуудын хувийн мэдээллийг гадагш задруулахгүй байх;
 - 3.1.5. бусад.
- 3.2. Дадлага удирдагч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:
- 3.2.1. дадлагажигч оюутныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, дадлагын гүйцэтгэлд хяналт тавих;
 - 3.2.2. дадлагажигч оюутанд хүрээлэнгийн дотоод дүрэм, журмыг танилцуулах, шаардлагатай судалгаа, мэдээллээр хангах;
 - 3.2.3. дадлагын удирдамж, төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар оюутанд даалгавар өгөх;
 - 3.2.4. дадлагажигч оюутны сар бүрийн ажлын тэмдэглэлтэй танилцаж, хянах (хийсэн ажлын тэмдэглэлийг Хавсралт 1-ээс харна уу)
 - 3.2.5. үйлдвэрлэлийн дадлагажигч оюутны дадлагын тайланг хянаж, тодорхойлолт бичих.
- 3.3. Дадлагажигч оюутан дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:
- 3.3.1. дадлагын удирдамжид нийцүүлэн дадлагын төлөвлөгөөг боловсруулах;
 - 3.3.2. үндсэн хуулийн эрх зүйн чиглэлээр судалгаа хийх;
 - 3.3.3. хүрээлэнгээс явуулж буй судалгаанд туслах;
 - 3.3.4. хүрээлэнгийн өдөр тутмын үйл ажиллагаанд туслах;
 - 3.3.5. дадлага хийх явцад олж мэдсэн хувь хүн, байгууллага, төрийн нууцыг задруулахгүй байх;
 - 3.3.6. судалгааны хийх болон туслах чиг үүрэгтэй оролцохдоо судалгааны ёс зүйтэй байх.

Дөрөв.Бусад

- 4.1. Дадлагажигч оюутан байгууллагын эд хөрөнгө, баримтыг ашиглаж байгаад үрэгдүүлсэн, гэмтээсэн бол хохирлыг бүрэн хариуцна.
- 4.2. Энэ журмыг зөрчсөн албан тушаалтан, оюутанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ

ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭЛЭНД ДАДЛАГА ХИЙХ ОЮУТАНД ТАНД ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨ¹

1. Шүүмжлэл бол ирээдүйн алдаанаас чинь сэргийлж буй дохио

Таны удирдагч болон хамт ажиллагсад тань заримдаа хатуу үг хэлэх болно. Хэдийгээр та бусдад шүүмжлүүлсэн байж болох ч нулимс, уурандаа автаж, их сэтгэл хөдлөлтэй байх нь таныг төлөвшөөгүй, мэргэжлийн бус харагдуулна. Тэгээд ч та дадлагажигч байхдаа галын шугаманд гарч, өндөр хариуцлага үүрэхгүй тул шүүмжлэлийг ирээдүйд болж магадгүй тааламжгүй үйл явдлуудыг даван туулах чадвараа яг одоо сайжруулах боломж гэж хараарай.

“Шүүмжлэлийг өөртөө тусган авах хэрэггүй. Оронд нь үүнийг надаас туршлагатай хүн надад зааж сургахын тулд хэлж байгаа бэлэг гэж ойлго. Хэрэв хэн нэгэн танд хатуу шүүмж хэлвэл, бүр дараа нь түүн дээр очоод хэрхэн энэ алдааг ирээдүйд гаргахгүй байх талаар асуу. Таны сурч мэдэх гэсэн эрмэлзэл тэднийг гайхшруулах болно” Мэтт Шарп (өмгөөлөгч)

2. Цаг баримтлах болон амласандаа хүрэх нь чухал чадвар

Хуулийн салбарт цаг баримтлах нь онцгой чухал. Цаг баримтлах нь мэргэжлийн ур чадвар, ажилдаа үнэнч байхыг илэрхийлдэг.

Биелүүлж чадахгүй зүйлээ хэзээ ч битгий амла. Амласнаа цагт нь биелүүлдэг байх нь таньд итгэх итгэлийг нэмэгдүүлэх болно.

3. Хүмүүстэй албан ёсны бөгөөд хүндэтгэлтэй харилцах

Орчин үед ZET-үүдийн харилцааны хэлбэр нь эможи болон товчлолуудаар дүүрсэн үе юм. Тиймээс бусадтай хүндэтгэлтэйгээр, албан ёсны харилцаж байх нь судалгааны байгууллагын хувьд чухал соёл юм.

Бүдүүлэг байдал, эго нь дадлагажигч хүний үзүүлж чадах хамгийн муу шинж чанарууд юм. Хэдийгээр хэн нэгэн ажилдаа алдаа гаргасан ч тэдэнтэй эелдэг, хүндэтгэлтэй хандвал зохино. Хэдийгээр таны эелдэг байдал нь далд санаатай байх ёсгүй ч, аятайхан хамтрагч байх нь урт хугацаанд танд туслах болно.

4. Та туслах гэж очсон гэдгээ санаарай

“Дадлага хийх нь зөвхөн эхлэл” бөгөөд та энэ боломжийг хамгийн сайн ашиглах хэрэгтэй. Сэтгэгдэл төрүүлэх хамгийн сайн арга бол цэвэрхэн хувцаслан, жижиг гэлтгүй аливаа ажилд туслаж байгаарай. Энэ нь цаашдаа гайхалтай туршлага төдийгүй, тэд таныг байгууллагын хувьд хамгийн сайн зүйлийг хийхэд бэлэн багийн тоглогч гэдгийг анзаарах болно.

¹ Уг зөвлөмжийн санааг: <https://www.enjuris.com/students/legal-internship-etiquette.html>

Хавсралт 1. Дадлагажигч оюутны хийсэн ажлын тэмдэглэл

Сар	Өдөр	Хийсэн ажлын тэмдэглэл
9	1	
	2	
	5	
	6	
	7	
	8	
	9	
	12	
	13	
	14	
	15	
	16	
	19	
	20	
	21	
	22	
	23	
	26	
	27	
	28	
29		
30		
<i>Дадлага удирдагчын гарын үсэг</i>		